

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.	Аудитын гэрчилгээ	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12.	Шилэн дансны мэдээлэл	9
2.13.	Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14.	Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал.....	10
3.1	Зардлын данстай холбоотой асуудал.....	10
3.2	Зардлын данстай холбоотой асуудал.....	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4	Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
4.5	Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	20
4.6	Аудит хийсэн Нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан.....	22
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	23

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ
ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЭНХБОЛД ТАНАА

2020.02.21 № 06/554
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энхболд Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн цалин хөлс дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэхтэй холбоотой зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 17-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал Т.Одончимэг хоёр дахь шатны, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг анхан шатны хяналт хэрэгжүүлэхээр, ахлах аудитор Б.Цогзолмаа, О.Цэндхүү, аудиторын туслах Т.Алтанчимэг, М.Батмагнай, Х.Гэрэлбаяр, Ш.Тэгш-Ерөөлт нар хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 6/59 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь "Эрүүл мэндийн цогц, шуурхай, чанартай үйлчилгээг өндөр мэдлэг бүхий эмч, мэргэжилтнүүд, дэвшилтэт технологид тулгуурлан үзүүлж үйлчлүүлэгчийн амьдралын чанарыг сайжруулна" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дурангийн мэс засал
- Лабораторийн үйлчилгээ
- Уян дурангийн оношилгоо, эмчилгээ
- Бөөр судлал
- Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж
- Өвдөлт намдаах тусламж, үйлчилгээ
- Диабетын тусламж, үйлчилгээ
- Сэргээн засах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 тоот тогтоолоор "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам", "Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам", "Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам";
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 тоот тогтоолоор "Төрийн албан хаагчид шагнал олгох журам", "Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт", "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам";
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 276 дугаар тогтоолоор баталсан "Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл", "Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл";
- "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 24 дүгээр тогтоол;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 74 дугаар тушаалаар баталсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус эмнэлэг нь 2019 онд Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулан мөрдөж байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Даймонд” програм хангамж ашигладаг байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Улсын хоёрдугаар төв эмнэлгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 6 чиглэлд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны гуравдугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 11,085,288.1 мянган төгрөгөөс тооцон 221,705.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 311,597.4 мянган төгрөгөөр тооцсон нь Улсын хоёрдугаар төв эмнэлгийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, үйл ажиллагааны орлого, зардалд эрсдэл бага байгаатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,043,827.1 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, биет хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9.0	10.0	1.0
Авлага	45,000.0	1,785.9	-43,214.0
Урьдчилгаа	11,682.3		-11,682.3
Бараа материал	919,374.4	1,527,015.0	607,640.4
Биет хөрөнгө	8,491,557.0	9,988,602.2	1,497,045.2
Биет бус хөрөнгө	1,522,814.5	1,516,851.3	-5,963.2
Нийт хөрөнгө	10,990,437.3	13,034,264.4	2,043,827.1
Өр төлбөр	21,478.0	31,228.4	9,750.4

Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/	11,941,287.1	11,941,287.1	
Хуримтлагдсан үр дүн	-5,944,118.0	-3,910,041.3	2,034,076.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,971,790.2	4,971,790.2	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	10,990,437.3	13,034,264.4	2,043,827.1

Авлагын дансны үлдэгдэл 43,214.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны эхний үлдэгдэл 45,000.0 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, тайлант оны эцэст татварын хэлтэст хувь хүний орлогын албан татварт 1,785.9 мянган төгрөгийг илүү төлсөнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 607,640.4 мянган төгрөгөөр өссөн нь 361,020.4 мянган төгрөгийн эмнэлгийн багаж, хэрэгсэл, бараа материал үнэ төлбөргүй шилжиж ирсэн, 246,620.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, хангамжийн материалын үлдэгдэл нь шинээр худалдан авсан бараа материалын өсөлттэй холбоотой байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 17.6 хувь буюу 1,497,045.2 мянган төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Тус эмнэлэг тайлант онд 29,007.5 мянган төгрөгөөр тавилга, компьютер хэрэгслийн худалдан авалт хийсэн;
- Эрүүл мэндийн яамнаас хөрөнгө оруулалтаар 263,320.0 мянган төгрөгийн зөөврийн рентген аппарат, суурин угаалгын машин, хатаагч нийлүүлсэн;
- МОН-98 төслийн санхүүжилтээр барилгын засвар үйлчилгээ, эмнэлгийн тоног төхөөрөмж, компьютер, техник хэрэгсэлд нийт 2,452,511.5 мянган төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хогшил үнэ төлбөргүй шилжиж ирсэнтэй холбоотойгоор нэмэгдэж;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-1/4180 дугаар шийдвэрээр 87,659.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 86,927.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 731.8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 5,963.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны хорогдуулалтын зардал гарсантай холбоотой.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,750.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь резидентэд хамрагдсан хувиараа суралцагч зардлаа 2 жилээр урьдчилан төлсөнтэй холбоотойгоор нэмэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг тайлант онд 16,022,797.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 14,437,803.7 мянган төгрөгийг зарцуулж 90.1 хувиар гүйцэтгэлтэй байна.

Тайлангийн хугацаанд нийт 9,860 хүн хэвтэн эмчлүүлж, оношилгоо шинжилгээнд 203,896 хүн, амбулаторийн үзлэгт 114,635 хүн тус тус хамрагдаж, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой улсын төсвөөс 4,135,352.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 8,545,015.3 мянган төгрөг, үндсэн ба туслах үйл ажиллагаанаас 1,757,435.9 мянган төгрөг нийт 14,437,803.7 мянган төгрөгийн төсөв төвлөрснөөс урсгалд зардалд 14,437,802.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь тайлант онд улсын төсвөөс 4,154,190.7 мянган төгрөгийн санхүүжилт авч 4,135,352.5 мянган төгрөгийг зарцуулан 18,838.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Тус эмнэлгийн үндсэн үйл ажиллагааны орлого 181,505.9 мянган төгрөгөөр тасарсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Тайлант оны төсөвт 2019 оны 7 дугаар сараас үндэсний оношилгоо эмчилгээний төв ашиглалтад орохоор тооцож орлогыг баталсан боловч 12 дугаар сараас үйл ажиллагаа нь эхэлж мэс заслын 2 дугаар тасаг, шинээр нээгдэх байсан харвалт, шигдээсний хэсэг, цөмийн оношилгооны тасаг ажиллаагүй, MRI, Компьютер томограф, ПЭТ-КТ шинжилгээний аппарат ашиглалтад ороогүйгээс зарим шинжилгээ, оношилгоо огт хийгдээгүй;
2. Амбулаторийн кабинетууд түр хааж барилгад урсгал засвар хийгдсэн тул эмнэлгийн тусламж үйлчилгээний орлого тасарсан байна.

Үүнтэй холбоотойгоор өндөр өртөг бүхий мэс засал хийлгэж хэвтэн эмчлүүлэх иргэдийн тоо буурснаас Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 1,399,611.0 мянган төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байна.

Үндэсний оношилгооны төв хугацаандаа ашиглалтад ороогүйтэй холбоотой орон тоо дутуу ажилласнаас цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, байрны ашиглалтын зардал болох цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, эмнэлэг үйлчилгээтэй холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, тавилга, хангамжийн зардлууд дутуу санхүүжигдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Улсын хоёрдугаар төв эмнэлэг нь тайлант онд 127,381.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар авч зарцуулсан байна. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сангаас Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, эмийн зохистой хэрэглээний сурталчилгаанд 67,000.0 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын газраас элэг бүтэн хөтөлбөр төслийн хүрээнд 22,607.0 мянган төгрөг;
- Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс резидентийн сургалтын төлбөрт 18,422.4 мянган төгрөг;
- Олон улсын сувилагчийн өдрөөр Монгол Улсын хөдөө, хотын нийт сувилагч нарын төлөөллийг хүлээн авч, сургалт семинар зохион байгуулах арга хэмжээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон Мед Монгол ХХК-иас 10,352.2 мянган төгрөг;
- Хас банкнаас нийгмийн хариуцлагын хүрээнд эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд 9,000.0 мянган төгрөгийн хандив, санхүүжилт тус тус хийгдсэн.

Дээрх санхүүжилтийг Сангийн сайдын 73 тоот тушаалаар төрийн сангийн журмын дагуу төсвийн зарцуулах эрх авч, эмнэлгийн захирлын баталсан төсөв, удирдамжийн дагуу зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 16 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 111,698.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 2,525.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 106,100.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,072.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

1. Мэс заслын тасгийн 3 болон 6 дугаар сарын эм, тарианы зарцуулалтыг шалгахад 5582 ширхэг 2,525.7 мянган төгрөгийн ашиглагдаагүй эм, тариаг буцаалт хийлгүйгээр зарлагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

- Тендерийн хавтаст хэргийн баримтын бүрдэл хангалтгүй, тендерийн баримт бичигт заасан шалгуурыг үнэлгээний хуудаст бүрэн тусгаагүй, 17,800.0 мянган төгрөгийн урсгал засварын ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулахдаа худалдан авах ажиллагааны цахим системд мэдээллийг байршуулаагүй, 106,100.0 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг байршуулалгүйгээр эм ханган нийлүүлэгч 10 компанитай гэрээ байгуулан худалдан авалтыг хийсэн зэрэг зөрчилтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т “Тендерийн хавтаст хэрэг дараахь баримт бичиг, материалаас бүрдэнэ”, 43 дугаар зүйлийн 43.4-т “Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана: 43.4.2-д 100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах;” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн 3,072.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн харьяанд Үндэсний оношилгоо эмчилгээний төвийг 2019 оны 7 дугаар сард ашиглалтад хүлээн авах байсан боловч улсын комисс хүлээн аваагүйгээс тус төвийн барилга байгууламж, 144 нэр төрлийн 1569 ширхэг багаж, тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Иймд дараагийн аудитаар тус асуудлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Улсын хоёрдугаар төв эмнэлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 90 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 111,698.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 221,705.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Засгийн газрын 382 дугаар тогтоолын 3 болон 5 дугаар хавсралтад заасан зэргийн нэмэгдлийн хувь хэмжээг зөрүүтэй тооцсоноос 7 ажилтанд 2,817.1 мянган төгрөг илүү, 1 ажилтанд 255.2 мянган төгрөг дутуу олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид Докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журмын 2-д заасан эрдмийн зэрэг цолны ангилалд "Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох шинжлэх ухааны доктор зэрэг 20 хувь", тус тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журмын 2-т "...эмнэлгийн мэргэжилтэн "Албан тушаалын сарын үндсэн цалингаас бодох ахлах зэрэг 10 хувь", -тай тэнцэх хэмжээний зэргийн нэмэгдэл олгохоор тусгасан заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Цалин хөлсний нэмэгдлийг тогтоосон дүрэм, журам зөрчин илүү олгох;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид Докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журмын 2-д заасан эрдмийн зэрэг цолны ангилалд тогтоосон хувь хэмжээ, 5 дугаар хавсралтад заасны дагуу цол зэргийн нэмэгдлийг тогтоосон хувиар тус тус зөрүүгүй тооцож олгох;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Эмнэлгийн ерөнхий захирлын 2020 оны А/13 дугаар тушаалаар Эмнэлгийн мэргэжилтэнд боловсролын докторын зэргийн нэмэгдлийг 15 хувиар, мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 2020 оны 1 сараас олгож эхэлсэн.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Цалин хөлстэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Тэтгэвэрт гарсан 7 хүнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулахдаа тэтгэвэрт гарахын өмнө олгож байсан төрийн албан хаагчийн сүлжээний цалинг хөдөлмөрийн гэрээнд тусгаж олгосон байна;
- Ажилласан жилийг үнэн зөв тооцсон эсэхийг түүвэрлэн 10 ажилтны материалыг тулган шалгахад 3 ажилтны ажилласан жил 1-2 жилээр зөрүүтэйгээр тусгагдсан тул ээлжийн амралтын хоногийг буруу тооцох үндэслэл болж байна;
- Нэг ажилтны жирэмсний амралттай байх үед нийгмийн даатгалын шимтгэлийг байгууллагаас төлөлгүйгээр тасалдуулсан;
- Ээлжийн амралтын мэдэгдэх хуудсыг цалин хөлсний нягтлан бодогчид олгоогүйгээс ажлаас гарсан ажилтнуудын ээлжийн амралтын тооцоог шалгахад хүндрэлтэй, зөрүүг тооцох боломжгүй байна.

Эдгээр нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т зааснаар төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгохоор өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл төрийн албанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж болох бөгөөд цалин хөлс нь зөвхөн хөдөлмөрийн гэрээнд зааснаар тодорхойлогдоно. Мөн Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 3-т “Ажил олгогч нь ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг тэдний саналыг үндэслэн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохицуулж, календарийн жилийн эхний улиралд багтаан гаргах ба баталсан хуваарийн дагуу энэ зааврын 1 дүгээр хавсралтаар баталсан ээлжийн амралт олгох мэдэгдлийг санхүү болон ажилтанд олгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Ажиллагсдын цалин хөлс, ээлжийн амралтын тооцоог буруу тооцож олгох;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Тэтгэвэрт гарсан ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа төрийн албаны сүлжээний цалингаар бус тохиролцсон цалин хөлсийг гэрээнд тусгах, ажилтнуудын ажилласан жилийн мэдээллийг зөрүүгүй болгох, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын дагуу цалин хөлсний нягтлан бодогч болон ажилтанд олгох;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- Засгийн газрын тогтоолын шатлалаар заасан байгаа цаашид тохиролцон тоо хэмжээгээр гэрээнд зааж оруулна.
- Хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтрийг ажилтан өөрөө шалгуулаагүй тохиолдлууд байна.
- Ажлаас гарсан эмнэлгийн мэргэжилтэн, ажилтны тооцоог “Ажлаас гарах тойрох хуудас”-аар тооцоо хийх бөгөөд санхүүгийн алба цалингийн тооцооны хүснэгт, ээлжийн амралт тооцооны хүснэгтийг үндэслэн тооцоо хийдэг.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	976,065,744.75	1,528,810,916.01
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	9,000.00	10,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,000.00	10,000.00
3121	Төгрөг	9,000.00	10,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	9,000.00	10,000.00
33	АВЛАГА	45,000,000.00	1,785,949.00
335	Бусад авлага	45,000,000.00	1,785,949.00
3351	Байгууллагаас авах авлага	45,000,000.00	1,785,949.00
34	УРЬДЧИЛГАА	11,682,300.00	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	4,382,300.00	0.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	7,300,000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	919,374,444.75	1,527,014,967.01
351	Түүхий эд материал	139,548,591.51	380,107,913.33
35110	Тусгай зориулалттай материал	14,395,042.88	11,163,860.00
35130	Эм боох материал	125,153,548.63	368,944,053.33
35410	Бичиг хэргийн материал	5,477,072.99	6,913,966.20
35420	Аж ахуйн материал	15,714,908.58	43,855,672.77
35430	Сэлбэг хэрэгсэл	77,780.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	4,036,773.93	6,678,327.60
35450	Барилгын засварын материал	2,994,162.50	3,245,152.50
35460	Хүнсний материал	5,582,345.12	33,009,102.43
35470	Бусад хангамжийн материал	745,942,810.12	1,053,204,832.18
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,014,371,518.18	11,505,453,498.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,014,371,518.18	11,505,453,498.84
392	Биет хөрөнгө	8,491,556,999.37	9,988,602,211.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,093,560,640.35	7,215,497,759.35
39202	Хуримтлагдсан элэгдэл	-10,040,075.30	-553,702,830.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	238,151,618.00	263,814,659.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-211,788,772.04	-220,075,359.87
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,089,030,614.79	7,588,455,514.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	-5,145,884,668.99	-5,586,221,309.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,344,904,982.86	2,355,365,903.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-1,050,715,591.14	-1,200,071,098.53
39214	Бусад үндсэн хөрөнгө	206,951,859.00	206,645,859.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-62,613,608.16	-81,106,885.71
393	Биет бус хөрөнгө	1,522,814,518.81	1,516,851,287.74
39301	Програм хангамж	93,062,350.00	93,062,350.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-75,173,091.19	-81,136,322.26
39303	Бусад биет бус хөрөнгө	1,504,925,260.00	1,504,925,260.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	10,990,437,262.93	13,034,264,414.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,478,000.00	31,228,449.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,478,000.00	31,228,449.00
413	Өглөг	0.00	2,004,449.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	2,003,449.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	0.00	1,000.00
414	Урьдчилж орсон орлого	21,478,000.00	29,224,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,968,959,262.93	13,003,035,965.85
51	Засгийн газрын хувь оролцоо	10,968,959,262.93	13,003,035,965.85

Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

